



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН**  
**БАЙНГЫН ХОРОО**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

*2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-7

---

- 1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/* 5 - 6
- 2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 6 - 7

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 5 дугаар сарын 17-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 02 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.*

*Томилолттой: Т.Аубакир;*

*Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Н.Учрал, Ж.Чинбүрэн, С.Чинзориг;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг;*

***Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн захирал Х.Баасанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Мөнхцэцэг:** Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 0  
Бүгд: 9  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

*Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн захирал Х.Баасанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 9 минут үргэлжилж, 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 18 цаг 11 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
*2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим  
18 цаг 02 минут*

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Г.Мөнхцэцэг:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Байнгын хорооны ирц бүрдсэн тул хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Ирц Гомпилдоогийн Мөнхцэцэг 6 дугаар тойрог, Дундговь Говьсүмбэр аймаг, Амгалангийн Адьяасүрэн Баянхонгор аймаг 3 дугаар тойрог, Пүрэв-Очирын Анужин Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар тойрог. Чөлөөтэй байна. Тилеуханы Аубакир Баян-Өлгий аймаг, 2 дугаар тойрог. Чөлөөтэй байгаа юм байна. Орон нутагт томилолттой байгаа юм байна. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг Архангай аймаг, 1 дүгээр тойрог. Чөлөөтэй байна. Балжиннямын Баярсайхан Завхан аймаг, 9 дүгээр тойрог. Ирсэн байна. Энхбаярын Батшугар 28 дугаар тойрог, Сонгинохайрхан дүүрэг. Ирсэн байна. Хассуурийн Ганхуяг Баянгол дүүрэг, 26 дугаар тойрог. Ирсэн байна. Гонгорын Дамдинням Дархан-Уул аймаг, 19 дүгээр тойрог. Ирсэн байна. Бадарчийн

Жаргалмаа Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар тойрог. Ирсэн байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг 24 дүгээр тойрог. Өвчтэй байна. Чинбатын Ундрэм Сэлэнгэ аймаг, 13 дугаар тойрог. Ирсэн байна. Ням-Осорын Учрал ирж байна. Тийм ээ. Сонгинохайрхан дүүрэг 28 дугаар тойрог, Жигжидсүрэнгийн Чинбүрэн Баянзүрх дүүрэг, 23 дугаар тойрог. Чөлөөтэй байна. Содномын Чинзориг Өвөрхангай аймаг, 10 дугаар тойрог. Одоогоор ирцэд ороогүй байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Хөвсгөл аймаг 17 дугаар тойрог. Ирсэн байна.

Байнгын хорооны хуралдааны ирц танилцуулагдаж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэхээр.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төсөл.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Анхны хэлэлцүүлэг байгаа.

Ингээд хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Гишүүн байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

*Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл  
/Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
хоёр дахь хэлэлцүүлэг/*

Монгол Улсын Үндсэн хуульд харуулах өөрчлөлтийг төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлдэх талаар хэлэлцье.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил харилцаа холбооны дэд сайд, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дорждэрэмийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Нинжбатын Ууганбаатар Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны их сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор.

Ийм бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хуралд оролцож байна.

Хэлэлцүүлж эхлэхийн өмнө холбогдох заалтуудыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-д Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд

оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал дүгнэлтээ гаргана.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө гэж тус тус заасан байна.

Хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна. Асуух асуулттай гишүүд алга.

Санал хураах хэсэг рүү орёё.

Санал хураалт явуулахаас өмнө холбогдох хуулийн заалтуудыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.2 дахь хэсэгт Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж, саналаа урьдчилан бичгээр томьёолж, хуралдаан даргалагчид өгсний үндсэн дээр түүнийхээ үндэслэлийг тайлбарлан 5 минутаас илүүгээр хугацаанд үг хэлж санал хураалгах эрхтэй байна.

Гишүүн хуралдаанд өөрөө оролцоогүй ч гэсэн саналыг хэлэлцэж, санал хурааж явуулна гэсэн ийм заалт байна.

49.3 дугаар хэсэгт энэ хуулийн 49.2-т заасан санал нь Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй бол Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлан үг хэлж, санал хураалгах хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно гэж заасан байна.

49.5 дахь хэсэгт саналын нэг томъёоллоор гурав хүртэл удаа санал хурааж болох бөгөөд хоёр удаа Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны

***Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих тухай журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу?

дэмжсэн санал гэж тооцон нэгдсэн хуралдаанд оруулна.

49.10 дахь хэсэгт зарчмын зөрүүтэй саналаар санал хураахдаа төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр нь хамтатган санал хураана гэж тус тус заасан байна.

Зарчмын зөрүүтэй санал хураалттай гишүүд байхгүй байна. /алх цохив/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Энэ санал 100 хувь дэмжигдлээ.

Дараагийн асуудал асуудалдаа орёе.

Гишүүд алга байна.

Энэ зүйл дээр санал гаргасан гишүүд байна уу?

Байхгүй байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Санал гаргах гишүүн байна уу?

Санал гаргах гишүүн алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Санал байна уу? Алга байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих тухай журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн

анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.  
/алх цохив/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн гишүүн танилцуулна.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.  
Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

*Хуралдаан 9 минут үргэлжилж, 18 цаг 11 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**